



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

“Нэйшнл лайф даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үүсгэн байгуулагч “Эф Эс Си Өү” ХХК-ийн хөрөнгө оруулалтын 650,000,000 /зургаан зуун тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	“Эф Эс Си Өү” ХХК	3,350,000,000	650,000,000	4,000,000,000	100
	Нийт	3,350,000,000	650,000,000	4,000,000,000	100

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2014 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Нэйшнл лайф даатгал” ХХК /Г.Монголхүү/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000027